

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгээс 2014 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Дээрх хуулийн төслүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь зөвхөн эмнэлгийн нөхцөлд хэрэглэх эм борлуулах эмийн сантай байх тухай заажээ.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүн А.Бакей энэ төсөл Зөвшөөрлийн тухай хуультай хэрхэн нийцэж байгаа тухай, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ төсөлд тусгасан нэр томъёо, утга тодорхой бус байна. Эмнэлгийн доторх эмийн сангийн бодлого, зохицуулалт, хяналтыг хэн тавих тухай төсөлд тусгагдаагүй байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан намрын чуулганаар батлагдсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолтой хэрхэн уялдаж байгаа талаар хуулийн төсөл санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан, Д.Батцогт, А.Тлейхан нар эрүүл мэндийн салбарт санхүү, удирдлага, зохион байгуулалт, менежментийн шинэчлэл хийснээр чөлөөт өрсөлдөөнийг бий болгож, улмаар эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах болно гэсэн санал гаргав.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.


Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Д.БАТЦОГТ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2014 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон
Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төслийг буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

Гарын үсэг